

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БАТЛАН ХАМГААЛАХ ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ
ДУНДГОВЬ АЙМАГТ ТӨЛӨӨЛӨН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН
ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 11 дүгээр сарын 28

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Батлан хамгаалах яамны сайд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР.ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Аймгийн Засаг даргын Батлан хамгаалах яамны сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Цэргийн штабаас ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.


Аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж хэрэгжилт удаашралтай арга хэмжээний жагсаалтыг гарган холбогдох хэлтэст хүргүүлэн цаашид анхаарах асуудал дээр зөвлөмж өгч ажилласан.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН


Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 31 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн эхний хагас жилд хяналт-шинжилгээ хийж удаашралтай арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх талаар зөвлөгөө зөвлөмж өгч ажилласнаар жилийн эцсийн байдлаар 96,6 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Гэрээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар зорилт тус бүрээр харуулбал:

№	Зорилтын нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1.	“Батлан хамгаалах бодлого хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэрээний заалтын хүрээнд:	8	100
2.	”Цэргийн бүртгэл, цэрэг халалт, татлагыг зохион байгуулах, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдтэй сургалт явуулах, мөнгөн төлбөрийн тооцоо хийх” гэрээний заалтын хүрээнд:	9	97
3.	“Дайчилгааны төлөвлөгөөг боловсруулж, тодотгох, даалгаваржуулах, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах” гэрээний заалтын хүрээнд:	5	100
4.	“Орон нутгийн хамгаалалтын төлөвлөлт, түүний хэрэгжилтийг хангах,болзошгүй гамшгийн аюулын үед харилцан ажиллах бэлтгэлийг хангах” гэрээний заалтын хүрээнд:	6	86,6
5.	”Батлан хамгаалах эдийн засгийг бэхжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх” гэрээний заалтын хүрээнд	3	100
Дүн		31	96,6



Монгол улсын засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг Дундговь аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд нийт 31 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 28 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээ 76.6 хувь, 1 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 50 хувьтай үнэлэгдлээ.



Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөлт, түүний хэрэгжилтийг хангах, болзошгүй гамшгийн аюулын үед харилцан ажиллах бэлтгэлийг хангах” гэрээний заалтын хүрээнд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн хувь нь 96,6 хувьтай үнэлэгдсэн байна. Тус зорилтын хүрээнд Батлан хамгаалах газрын даргын удирдлагын байрыг шинээр төхөөрөмжлөх арга хэмжээний төсөвт хөрөнгийг шийдвэрлэх хөрөнгө санхүүгийн шалтгаанаар үр дүнгүй хэрэгжсэн гэж үзэж болохоор байна.

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

Дорноговь аймгийн Эрдэнэ суманд байрлах Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн шинэ цэргийн алба хаагчдын тангаргийн баярын үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Цэргийн штабын дарга, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар, цэрэгжил спортын “Дөл” тэмцээнд тэргүүлсэн баг 13 сурагчид оролцсон.



“Онц байдал үүссэн үед Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжээр үүрэг гүйцэтгүүлэх нь” сэдэвтэй Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн “Хээрийн дадлага” сургалтыг сумын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган 80 оногдуулан бүртгэгдсэн иргэдтэй 2024 оны 09 дүгээр сарын 08-16-ны өдрүүдэд 9 хоногийн хугацаатай Эрдэнэдалай сумын “Эрэн хайх, аврах салбар”-ын байрлал “Наадмын цэнгэлдэх хүрээлэнг”-ийн районыг түшиглэн зохион байгуулсан.



Тус сургалтад аймгийн удирдлага, зохион байгуулах ажлын хэсэг, Батлан хамгаалах яам, ЗХЖШ, ТХЦК, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын 24 алба хаагч, томилгоот нэгжийн 80 оногдуулан бүртгэгдсэн үүрэгтэн, сумдын 15 Засаг даргын тамгын газрын дарга нар нийт 150 гаруй хүн оролцсон “Хээрийн дадлага”-ыг 2024 оны орон нутгийн төсөвт 50 сая төгрөгийг суулган, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан зарцуулсан.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан“ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр аймгийн Засаг даргын Батлан хамгаалах яамны сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Яамдын сайдтай байгуулсан гэрээний үүргийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд төлөвлөгөө гарган ажилладаг бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээг хийж зөвлөмж өгч ажилласнаар жилийн эцсийн байдлаар нийт 31 арга хэмжээ хэмжээний дундаж 96,6 хувьтай хувьтай үнэлэгдсэн. Тайлагналтад хяналт шинжилгээг тасралтгүй хийж зөвлөмж, арга зүйгээр хангаж ажилласнаар гэрээг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, тайлагналтад тодорхой үр дүнгүүд гарсаар байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад“Орон нутгийн хамгаалалтын төлөвлөлт, түүний хэрэгжилтийг хангах,болзошгүй гамшгийн аюулын үед харилцан ажиллах бэлтгэлийг хангах” хэрэгжилтийн хувь нь 86,6 хувьтай хамгийн бага хувьтай үнэлэгдсэн байна.Тус зорилтын хүрээнд Батлан хамгаалах газрын даргын удирдлагын байрыг шинээр төхөөрөмжлөх арга хэмжээний төсөвт хөрөнгийг шийдвэрлэх хөрөнгө санхүүгийн шалтгаанаар үр дүнгүй хэрэгжсэн гэж үзэж болохоор байна.

Аймгийн засаг даргын тамгын даргаар ахлуулсан ажлын хэсгийн бие бүрэлдэхүүн Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн шинэ цэргийн алба хаагчдын тангаргийн баярын үйл ажиллагаанд цэрэгжил спортын“ Дөл” тэмцээнд тэргүүлсэн баг 13 сурагчдыг хамруулсан нь цаашид эх орноо хамгаалах, эх оронч үзэл төлөвшүүлэх, бахархах зэрэг чадваруудыг эзэмшсэн үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байна.

“Онц байдал үүссэн үед орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжээр үүрэг гүйцэтгүүлэх нь”сэдэвт “Хээрийн дадлага”сургалтыг үр зохион байгуулсан нь орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх чадвар нэмэгдсэн.

Гэрээгээр хүлээсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсөв болон төсөл хөтөлбөрийн хүрээнд 142 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Цэргийн штабт:

1. Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахдаа үр дүнд чиглүүлж, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон хүрэх түвшнийг тодорхой, оновчтой судалгаа шинжилгээнд үндэслэн аймгийн бодлогын баримт бичгийн төлөвлөлттэй уялдуулан төлөвлөж байх

2. Тайланг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу хүрэх түвшинд хүрсэн эсэхийг тайлагнахаас гадна үр дүн, үр нөлөөний талаар тайлагнаж хэвших мөн нотлох баримтыг тайланд хавсаргаж тайлагнах

3. Дараа оны гэрээний төсөлд хэрэгжиж болохуйц, үр дүнтэй тодорхой ажлуудыг тусгуулахаар саналыг хүргүүлэх

БАТАЛГААЖУУЛСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

С.МӨНХЧУЛУУН

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ДААРИЙМАА

ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.МЯГМАРМЯДАГ